



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 5/м

Хэрлэн сум

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 194 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт батлах тухай” 274 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт оруулсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Жигжиидийн Ганбаатарын цалинг 2023 оны 1 дүгээр сарын 01-ээс эхлэн Т3-2 зэрэглэлээр шинэчлэн тогтоосугай.

2. Ж.Ганбаатрын үндсэн цалинг Т3-2 зэрэглэл 1,211,164 (нэг сая хоёр зуун арван нэгэн мянга нэг зуун жаран дөрвөн мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласан нэмэгдлийг 20 хувиар тооцож, бусад нэмэгдлийг холбогдох хууль, журмын дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

